

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
2009 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2010.02.22


Улаанбаатар хот

**НЭГ. ББСБ-ЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,
НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ**

2009 онд нийт 66 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 26 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор тайлант хугацааны эцэст нийт 177 ББСБ-ын санхүүгийн тайлан нэгтгэлд хамрагдлаа.

Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тоог өмнөх онуудтай харьцуулвал:

/График 1/



2009 оны жилийн тайлант хугацаан дахь ББСБ-уудын тайлангийн нэгтгэлийн голлох статистик үзүүлэлтүүдийг харуулбал /мянган төгрөгөөр/:

/Хүснэгт 1/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2008 оны IV улирал	2009 оны I улирал	2009 оны II улирал	2009 оны III улирал	2009 оны IV улирал
1	ББСБ-ын тоо	132	132	173	172	177
2	Хувь нийлүүлэгчдийн тоо	445	442	548	432	497
3	Ажиллагсадын тоо	657	603	730	759	746
4	Салбар нэгжийн тоо	42	46	58	57	58
5	Харилцагчдын тоо	120,007	40,223	48,957	84,484	108,293
6	Нийт актив /мянган төгрөгөөр/	78,530,740.2	79,142,638.6	85,291,455.3	89,320,627.4	96,480,115.7
	Банкны салбарт эзлэх хувь	2.15	2.00	2.20	2.21	2.18
7	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	46,446,274.0	46,029,757.4	48,085,208.8	49,954,945.9	55,504,753.9
	Банкны салбарт эзлэх хувь	1.7	1.7	1.8	1.9	2.02
8	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	55,017,655.3	59,294,746.6	65,734,186.0	68,888,094.1	74,840,502.0
	Банкны салбарт эзлэх хувь	16.1	17.2	20.3	27.6	32.5
9	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	46,737,684.5	50,953,035.0	58,857,930.6	61,421,490.8	66,367,214.5
	Банкны салбарт эзлэх хувь	21.4	20.3	26.9	25.5	25.9
10	Итгэлцлийн үйлчилгээний өглөг /мянган төгрөгөөр/	2,846,290.3	3,404,143.1	3,528,570.5	3,225,052.3	3,653,513.1
11	Нийт орлого /мянган төгрөгөөр/	18,896,996.8	8,356,435.2	13,379,966.3	19,596,686.5	26,680,675.1

12	Нийт зардал /мянган төгрөгөөр/	14,959,525.0	6,826,386.0	10,879,555.5	15,844,583.4	21,694,647.4
1	Тухайн үеийн ашиг /мянган төгрөгөөр/	3,937,471.9	1,530,049.2	2,500,410.8	3,752,103.1	4,986,027.7
14	Активын өгөөж /ROA/		8.70	2.48	5.10	4.56
15	Өөрийн хөрөнгийн өгөөж /ROE/		11.80	3.01	6.00	5.75
1	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын тоо	11	11	9	8	9
	ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь	8.30	8.30	5.20	4.60	5.08
A	Нийт актив /мянган төгрөгөөр/	17,408,566.7	15,471,456.7	11,761,259.4	12,694,871.0	13,780,371.4
	ББСБ-ын нийт активт эзлэх хувь	22.17	19.50	13.80	14.20	14.28
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	8,931,973.7	9,394,216.7	8,530,907.8	9,250,929.8	10,133,100.3
	ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	19.23	20.40	17.70	18.50	18.26
В	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	8,194,282.06	9,982,584.90	6,416,347.00	6,337,361.80	6,941,196.82
	ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь	14.89	16.80	9.70	9.20	9.27
Г	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	8,477,790.3	10,577,790.3	6,921,032.5	6,721,032.5	7,221,032.5
	ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь	18.14	20.80	11.80	10.90	10.88
2	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	23	23	26	26	27
	ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь	17.40	17.40	15.00	15.10	15.25
A	Нийт актив /мянган төгрөгөөр/	2,076,814.9	2,016,875.6	2,668,155.7	3,018,985.4	3,037,428.5
	ББСБ-ын нийт активт эзлэх хувь	2.64	2.50	3.10	3.40	3.15
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	1,649,692.9	1,641,054.8	1,600,288.9	2,260,602.5	2,123,585.5
	ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	3.55	3.60	3.30	4.50	3.83
В	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	1,718,290.6	1,696,113.8	1,793,485.6	2,713,231.2	2,795,081.3
	ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь	3.12	2.90	2.70	3.90	3.73
Г	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	1,399,359.1	1,459,320.9	1,480,831.4	2,393,459.2	2,643,455.9
	ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь	2.99	2.90	2.50	3.90	3.98
3	Валютын арилжааны үндсэн үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	1	1	44	47	47
	ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь	0.76	0.76	25.40	27.30	26.55

А	Нийт актив /мянган төгрөгөөр/	246,412.2	481,113.9	5,398,407.8	5,724,465.1	5,897,723.2
ББСБ-ын нийт активт эзлэх хувь		0.31	0.61	6.30	6.40	6.11
Б	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	245,218.5	479,780.0	5,338,119.0	5,699,789.3	5,874,953.3
ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь		0.45	0.81	8.10	8.30	7.85
В	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	200,000.0	400,000.0	5,207,356.4	5,046,367.1	5,179,194.0
ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь		0.43	0.79	8.80	8.20	7.80

Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ:

2009 оны жилийн эцсийн байдлаар гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 9 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 5.1 хувийг, тэдгээрийн нийт актив ББСБ-ын нийт активын 14.3 хувийг, нийт олгосон зээл, түүнтэй адилтган тооцох актив нь нийт ББСБ-уудын олгосон зээл, түүнтэй адилтган тооцох активын 18.3 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-уудын эзэмшигчийн өмчийн 9.3 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 10.9 хувийг тус тус эзэлж байна. Тэдгээрийг гадаадын хөрөнгө оруулагчдын харьяаллаар нь авч үзвэл, Дэлхийн Зөн Олон улсын байгууллагаас санхүүжигдсэн 1, Япон улсын хөрөнгө оруулалттай 4, БНСУ-ын хөрөнгө оруулалттай 1, Итали улсын хөрөнгө оруулалттай 1, АНУ-ын хөрөнгө оруулалттай 1, ОХУ-ын хөрөнгө оруулалттай 1 ББСБ тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ:

2009 оны жилийн эцсийн байдлаар орон нутагт 27 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 15.3 хувийг, тэдгээрийн нийт актив нь нийт ББСБ-ын активын 3.15 хувийг, нийт олгосон зээл, түүнтэй адилтган тооцох актив нь нийт ББСБ-ын 3.8 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчийн өмчийн 3.7 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 3.98 хувийг тус тус эзэлж байна.

/График 2/



Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа дангаар эрхлэн явуулж буй ББСБ:

Хорооны 2009 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн “Валютын арилжааг цэгцтэй болгох зорилгоор зарим тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 28 дугаар тогтоол батлагдсанаар валют солих цэгийн үйл ажиллагаа эрхэлж байсан, цаашид эрхлэх

хүсэлтэй аливаа этгээд нь банк бус санхүүгийн гадаад валютын арилжааг Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх эрх зүйн үндэс бүрдсэн.

2009 оны тайлант хугацааны эцсийн байдлаар гадаад валютын арилжааг дангаар эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 43 ББСБ, зээл, гадаад валютын арилжаа эрхлэх зөвшөөрөлтэй 4 ББСБ буюу нийт 47 ББСБ зөвхөн гадаад арилжааны үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 26.5 хувийг, тэдгээрийн нийт актив нийт ББСБ-ын активын 6.1 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчийн өмчийн 7.85 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 7.8 хувийг тус тус эзэлж байна.

2009 онд тусгай зөвшөөрлийн хугацаа нь дууссан 2 ББСБ-ын тусгай зөвшөөрлийн хугацааг 3 жилийн хугацаатай сунгасан байна.

ББСБ-уудыг Монгол Улсын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагаа, үйлчилгээг эрхэлж буйгаар нь ангилвал:

/Хүснэгт 2/

№	Үйл ажиллагааны нэр төрөл	Үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тоо /улирлаар/				
		2008 он	2009 он			
		IV	I	II	III	IV
1	Зээл	130	130	130	127	132
2	Факторингийн үйлчилгээ	7	7	5	5	6
3	Төлбөрийн баталгаа гаргах	5	3	5	5	5
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	0	0	0	0	0
5	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	9	7	7	5	5
6	Гадаад валютын арилжаа	55	51	99	102	104
7	Итгэлцлийн үйлчилгээ	14	13	12	12	11
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	3	3	2	3	2
9	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	8	8	8	9	7
10	Хөрөнгө оруулалтын үйлчилгээ	0	0	0	1	1


ББСБ-уудын олгож буй зээлийн хүүгийн болон татан төвлөрүүлсэн санхүүгийн эх үүсвэрт төлж буй хүүгийн түвшин:

/Хүснэгт 3/

№	Үзүүлэлт	Хүүгийн хувь				
		2008 он	2009 он			
		IV	I	II	III	IV
1	Дээд хүү /зээл, активын/	4.5	4.5	4.5	8.1	4.5
	Доод хүү /зээл, активын/	3.0	3.0	3.0	2.6	2.4
2	Дээд хүү /бусдаас татсан эх үүсвэрийн/	2.5	2.0	2.0	0.4	0.7
	Доод хүү /бусдаас татсан эх үүсвэрийн/	1.0	0.5	0.5	0.2	0.2

Банк болон ББСБ-уудаас олгосон буй зээлийн хүүгийн түвшин сүүлийн 10 жилийн хугацаанд дараах байдалтай байна.

/График 3/



2009 оны жилийн тайлант хугацааны эцсийн санхүүгийн болон зохистой харьцааны тайланг нийт ББСБ-ын 90.4 хувь буюу 160 ББСБ ирүүлсэн бол 17 ББСБ буюу нийт ББСБ-ын 9.6 хувь нь өмнөх үеүдийн санхүүгийн тайлангийн дүнгээр 2009 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлд хамрагдлаа.

ХОЁР. АКТИВЫН БҮТЭЦ, ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1 Активын бүтэц, өөрчлөлт:

ББСБ-уудын 2009 оны жилийн тайлант хугацааны нийт активын бүтцийг өмнөх онтой харьцуулан авч үзвэл дараах байдалтай байна.

/Хүснэгт 4/


№	ХӨРӨНГӨ	2009.12.31		2008.12.31		Өөрчлөлт	
		Дүн /мян. төг/	Хувь	Дүн /мян. төг/	Хувь	Дүн /мян. төг/	Хувь
A	Эргэлтийн хөрөнгө	92,326,922.2	95.7%	74,419,446.9	94.8%	17,907,475.3	19.4%
1	Мөнгөн хөрөнгө	31,019,402.0	32.2%	20,050,521.1	25.5%	10,968,880.9	35.4%
2	Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	1,948,117.6	2.0%	2,119,547.5	2.7%	-171,429.9	-8.8%
	(Хөрөнгө оруулалтын үнэт цаасны эрсдлийн сан)	0.0	0.0%	0.0	0.0%	0.0	0.0%
3	Нийт зээл	55,504,753.9	57.5%	46,446,274.0	59.1%	9,058,479.9	16.3%
	(Зээлийн эрсдлийн сан)	3,257,571.3	3.4%	1,972,041.7	2.5%	1,285,529.7	39.5%
4	Нийт санхүүгийн түрээсийн тооцооны авлага	1,079,999.6	1.1%	965.4	0.0%	1,079,034.1	99.9%
	(Санхүүгийн түрээсийн эрсдлийн сан)	497.7	0.0%	672.6	0.0%	-174.9	-35.1%
5	Нийт факторингийн тооцооны авлага	350.0	0.0%	350.0	0.0%	0.0	0.0%
	(Факторингийн авлагын эрсдлийн сан)	350.0	0.0%	350.0	0.0%	0.0	0.0%
6	Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	401,677.0	0.4%	72,072.1	0.1%	329,604.9	82.1%
	(ӨБҮХХ-ийн болзошгүй эрсдлийн сан)	34,460.1	0.0%	22,418.1	0.0%	12,042.0	34.9%
7	Бусад хөрөнгө	5,631,041.1	5.8%	7,702,780.9	9.8%	-2,071,739.8	-36.8%
B	Эргэлтийн бус хөрөнгө	4,153,193.5	4.3%	4,111,293.3	5.2%	41,900.2	1.0%
8	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө /цэврээр/	4,153,193.5	4.3%	4,111,293.3	5.2%	41,900.2	1.0%

Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	5,525,277.3	5.7%	5,179,535.2	6.6%	345,742.1	6.3%
(Хуримтлагдсан элэгдэл)	1,372,083.9	1.4%	1,068,242.0	1.4%	303,841.9	22.1%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	96,480,115.7	100.0%	78,530,740.2	100.0%	17,949,375.5	18.6%

2009 оны жилийн тайлант хугацаанд нийт актив өмнөх оны мөн үеэс 18.6 хувиар өссөн ба ийнхүү өссөн нь ББСБ-уудын өөрийн хөрөнгө буюу эзэмшигчдийн өмч 26.5 хувь /үүнээс: хоёрдогч өглөг 47.6 хувь/, итгэлцлийн үйлчилгээний өглөг 22.1 хувь өссөнтэй шууд холбоотой.

Тайлант хугацааны эцсийн байдлаар нийт актив хөрөнгийн бүтцийг хувиар илэрхийлбэл дараах байдалтай байна.


/График 4/



Тайлант хугацаан дахь зээлийн үлдэгдэл нь нийт активын 57.5 хувь /цэврээр 54.0 хувь/, мөнгөн хөрөнгө 32.2 хувийг буюу нийт 89.7 хувийг эзэлж байгаа нь ББСБ-уудын үндсэн эрхэлж буй үйл ажиллагаа нь зээлийн үйл ажиллагаа байж, бусад санхүүгийн үйл ажиллагаа, үйлчилгээг төдийлэн эрхлэхгүй байгаатай шууд холбоотой.

ББСБ-уудын системийн нийт активын бүтцийг өмнөх онуудтай харьцуулбал дараах байдалтай байна.

/График 5/




2.2 Зээлийн багцын чанар:

Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

№	Ангилал	2009.12.31		2008.12.31		Өөрчлөлт	
		Дүн /мян. төг/	Хувь	Дүн /мян. төг/	Хувь	Дүн /мян. төг/	Хувь
1	Хэвийн зээл	47,399,071.6	85.4%	41,533,022.6	89.4%	5,866,049.0	12.4%
2	Хугацаа хэтэрсэн зээл	3,192,871.6	5.8%	2,270,967.2	4.9%	921,904.4	28.9%
3	Чанаргүй зээл. Үүнээс:	4,912,810.7	8.9%	2,642,284.2	5.7%	2,270,526.6	46.2%
	а/ Хэвийн бус	1,384,491.1	2.5%	1,031,142.3	2.2%	353,348.8	25.5%
	б/ Эргэлзээтэй	1,403,245.3	2.5%	269,488.8	0.6%	1,133,756.5	80.8%
	в/ Муу	2,125,074.2	3.8%	1,341,653.0	2.9%	783,421.2	36.9%
Нийт		55,504,753.9	100.0%	46,446,274.0	100.0%	9,058,479.9	16.3%


2009 оны жилийн тайлант хугацааны үзүүлэлтүүдийг өмнөх онтой харьцуулахад, нийт зээлийн багцад эзлэх хэвийн зээл 4.0 хувиар буурсан, хугацаа хэтэрсэн зээл 0.7 хувиар, чанаргүй зээл 3.2 хувиар тус тус өссөн байх ба тайлант хугацааны эцсийн байдлаар нийт зээлийн багцын бүтцийг хувиар илэрхийлбэл дараах байдалтай байна.

/График 6/



ББСБ-уудын системийн нийт зээлийн багцын бүтцийг өмнөх онуудтай харьцуулбал дараах байдалтай байна.

/График 7/



Графикаас харахад өнгөрсөн 10 жилийн хугацааны туршид зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ 2007 онд хамгийн өндөр үзүүлэлттэй байсан ба 2009 онд

өмнөх оноос 3.2 хувиар өссөн нь санхүү, эдийн засгийн хямралтай холбоотойгоор зээлдэгчдийн үйл ажиллагааны орлого буурсан, барьцааны эд зүйлийг худалдан борлуулах замаар зээлийг эргэн төлүүлэх хууль эрх зүйн орчин төдийлэн таатай бус байгаа, зарим ББСБ-уудын удирдлагын хувьд зохих менежментийг хангаж ажиллаж чадахгүй байгаатай холбоотой юм.

ГУРАВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ӨӨРЧЛӨЛТ

ББСБ-уудын 2009 оны жилийн тайлант хугацааны нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх онтой харьцуулж үзвэл дараах байдалтай байна.

/Хүснэгт 6/

№	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	2009.12.31		2008.12.31		Өөрчлөлт	
		Дүн /мян. төг/	Хувь	Дүн /мян. төг/	Хувь	Дүн /мян. төг/	Хувь
A	Нийт өр төлбөр	21,639,613.6	22.4%	23,513,084.9	29.9%	-1,873,471.2	-8.7%
	<i>Өр төлбөр</i>	<i>17,847,461.9</i>	<i>18.5%</i>	<i>16,462,326.8</i>	<i>21.0%</i>	<i>1,385,135.1</i>	<i>7.8%</i>
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	3,653,513.1	3.8%	2,846,290.3	3.6%	807,222.8	22.1%
2	Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	10,689,685.1	11.1%	9,646,306.6	12.3%	1,043,378.5	9.8%
3	Бусад эх үүсвэр	757,561.5	0.8%	1,215,690.6	1.5%	-458,129.1	-60.5%
	<i>Зээлийн батлан даалтанд байршуулсан эх үүсвэр</i>	<i>1,059.3</i>	<i>0.0%</i>	<i>4,584.9</i>	<i>0.0%</i>	<i>-3,525.7</i>	<i>-332.8%</i>
	<i>Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг</i>	<i>665,873.5</i>	<i>0.7%</i>	<i>1,211,105.6</i>	<i>1.5%</i>	<i>-545,232.1</i>	<i>-81.9%</i>
	<i>Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг</i>	<i>0.0</i>	<i>0.0%</i>	<i>0.0</i>	<i>0.0%</i>	<i>0.0</i>	<i>0.0%</i>
	<i>Факторингийн үйлчилгээний өглөг</i>	<i>0.0</i>	<i>0.0%</i>	<i>0.0</i>	<i>0.0%</i>	<i>0.0</i>	<i>0.0%</i>
	<i>Гадаад валютын арилжааны эх үүсвэр</i>	<i>90,628.7</i>	<i>0.1%</i>	<i>0.0</i>	<i>0.0%</i>	<i>90,628.7</i>	<i>100.0%</i>
4	ББСБ-аас гаргасан өрийн бичиг	0.0	0.0%	0.0	0.0%	0.0	0.0%
5	Төслийн зээлийн санхүүжилт	2,746,702.2	2.8%	2,754,039.3	3.5%	-7,337.1	-0.3%
	Бусад өр төлбөр	3,792,151.7	3.9%	7,050,758.0	9.0%	-3,258,606.3	-85.9%
6	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	284,060.5	0.3%	263,575.4	0.3%	20,485.1	7.2%
7	Бусад пассив	3,508,091.2	3.6%	6,787,182.6	8.6%	-3,279,091.4	-93.5%
8	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн өглөг	0.0	0.0%	0.0	0.0%	0.0	0.0%
Б	Эзэмшигчдийн өмч	74,840,502.0	77.6%	55,017,655.3	70.1%	19,822,846.7	26.5%
9	Хувьцаат капитал	66,367,214.5	68.8%	46,737,684.5	59.5%	19,629,530.0	29.6%
10	Бусад өмч	496,841.8	0.5%	582,939.9	0.7%	-86,098.1	-17.3%
11	Сангууд	1,100,073.0	1.1%	1,108,233.7	1.4%	-8,160.7	-0.7%
12	Хуримтлагдсан ашиг/алдагдал	6,088,662.8	6.3%	6,176,033.8	7.9%	-87,371.0	-1.4%
13	Хоёрдогч өглөг /5 жилээс дээш хугацаатай/	787,710.0	0.8%	412,763.4	0.5%	374,946.6	47.6%
	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	96,480,115.7	100.0%	78,530,740.2	100.0%	17,949,375.5	18.6%


Тайлант хугацаанд өмнөх онтой харьцуулахад нийт өр төлбөр 8.7 хувиар буурсан, эзэмшигчдийн өмч 26.5 хувиар өссөн бөгөөд 2008 оны тайлант хугацаанд нийт пассивын 29.9 хувийг нийт өр төлбөр, 70.1 хувийг эзэмшигчийн өмч эзэлж байсан бол 2009 оны тайлант хугацааны нийт пассивт эзлэх өр төлбөр 22.4 хувь, эзэмшигчийн өмч 77.6 хувь болж өөрчлөгдсөн байна. Нийт пассивт эзлэх нийт өр төлбөр буурсан гол шалтгаан нь ББСБ-уудын итгэлцлийн үйлчилгээний өглөг, дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас

авсан зээлийн хэмжээ төдийлэн өсөөгүй, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг, бусад пассив буурсантай шууд холбоотой.

Итгэлцлийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй 11 ББСБ байгаагаас 2009 оны жилийн эцсийн тайлант хугацаанд тэдгээрийн нийт итгэлцлийн үйлчилгээний өглөгийн дүн 3,653,513.1 мянган төгрөг байгаа бол мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 5 ББСБ байгаагаас 2009 оны жилийн эцсийн тайлант хугацаанд тэдгээрийн нийт мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгийн дүн 665,873.5 мянган төгрөг байна. Мөн 2009 оны жилийн эцсийн тайлант хугацаанд 2-догч өглөгтэй 6 ББСБ байгаагаас тэдгээрийн нийт хоёрдогч өглөгийн дүн 787,710.0 мянган төгрөг байна.

2009 оны жилийн эцсийн тайлант хугацааны нийт пассивын бүтцийг хувиар илэрхийлбэл дараах байдалтай байна.

/График 8/




ББСБ-уудын өөрийн хөрөнгө буюу эзэмшигчдийн өмч 26.5 хувь /үүнээс: хоёрдогч өглөг 47.6 хувь/, итгэлцлийн үйлчилгээний өглөг 22.1 хувь өссөнтэй холбоотойгоор нийт эх үүсвэр өмнөх оны мөн үеэс 18.6 хувиар өсчээ.

Санхүүгийн үзүүлэлтүүдийн бүтцийн хувьд нийт пассивт эзлэх хувь хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад, нийт өр төлбөр 7.5 хувиар буурсан, нийт эзэмшигчдийн өмч 7.5 хувиар өссөн /үүнээс: дүрмийн сан 93.3, хоёрдогч өглөг 0,3 хувиар тус тус өссөн бол, бусад өмч 0.2, сан 0.3, хуримтлагдсан ашиг 1.6 хувиар тус тус буурсан/ байна. Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн эх үүсвэр өмнөх оноос 7.8 хувиар өссөн, өөрийн хөрөнгийн эх үүсвэр нэмэгдсэн нь ББСБ-уудын өөрийн хөрөнгөөр эрсдэл даах чадварыг нэмэгдүүлж, улмаар санхүүгийн тогтвортой байдлын хувьд эерэг үзүүлэлт болж байна.


Өөрийн хөрөнгийн өсөлтөд Хорооны 2008 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн “Банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 169 дүгээр тогтоолоор үүрэг болгосны дагуу ББСБ-ууд дүрмийн сангаа нэмэгдүүлсэн, мөн Хорооны 2009 оны “Валютын арилжааг цэгцтэй болгох зорилгоор зарим тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 28 дугаар тогтоолын дагуу шинээр гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх ББСБ шинээр олноор байгуулагдсан нь чухал үүрэг гүйцэтгэсэн.

ББСБ-уудын системийн эзэмшигчдийн өмч, дүрмийн сангийн хэмжээ, татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээг өмнөх онуудтай харьцуулбал дараах байдалтай байна.

/График 9/



/График 10/



ДӨРӨВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА

2009 оны жилийн тайлант хугацааны нийт орлого өмнөх оны мөн үеэс 41.2 хувиар өссөн ба дараах үндсэн бүтэцтэй байна.

/Хүснэгт 7/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2009.12.31		2008.12.31		Өөрчлөлт	
		Дүн /мян. төг/	Хувь	Дүн /мян. төг/	Хувь	Дүн /мян. төг/	Хувь
1	ХҮҮГИЙН ОРЛОГО	15,239,694.6	57.1%	11,596,669.1	61.4%	3,643,025.5	31.4%
	Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	14,570,271.1	54.6%	11,204,475.0	59.3%	3,365,796.1	30.0%
	Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	315,156.7	1.2%	152,512.8	0.8%	162,644.0	106.6%
	Үнэт цаасны хүүгийн орлого	24,551.5	0.1%	218.7	0.0%	24,332.9	11127.9%
	Бусад хүүгийн орлого	329,715.2	1.2%	239,462.6	1.3%	90,252.6	37.7%
2	ХҮҮГИЙН БУС ОРЛОГО	11,132,600.8	41.7%	6,845,487.2	36.2%	4,287,113.6	62.6%
3	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	292,516.4	1.1%	430,768.0	2.3%	-138,251.6	-32.1%
4	ЕРДИЙН БУС ОРЛОГО	15,863.3	0.1%	24,072.5	0.1%	-8,209.2	-34.1%
	НИЙТ ОРЛОГО	26,680,675.1	100.0%	18,896,996.8	100.0%	7,783,678.3	41.2%

2009 оны тайлант хугацааны нийт орлого өмнөх оноос 41.2 хувиар өссөн нь ББСБ-уудын эзэмшигчдийн өмчийн өсөлт, шинээр тусгай зөвшөөрөл авсан ББСБ-уудын тоо нэмэгдсэнтэй шууд холбоотой бөгөөд нийт орлогын өсөлтийн голлох үзүүлэлтүүд нь үндсэн үйл ажиллагааны орлого болох хүүгийн болон хүүгийн бус орлого байна.

Тайлант хугацааны нийт орлогын 57.1 хувийг хүүгийн орлого /өмнөх оны нийт орлогод эзлэх хүүгийн орлогын дүнтэй харьцуулахад 4.3 хувиар буурсан/, 41.7 хувийг хүүгийн бус орлого /өмнөх оны нийт орлогод эзлэх хүүгийн бус орлогын дүнтэй харьцуулахад 5.5 хувиар өссөн/ эзэлж байгаа нь 2009 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн “Валютын арилжааг цэгцтэй болгох зорилгоор зарим тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 28 дугаар тогтоолыг үндэслэн гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгож эхэлсэнтэй холбоотой. 2008 оны эцэст гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ-ын тоо 55 байсан бол 2009 оны эцэст 49-өөр нэмэгдэж тус үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ-ын тоо 104-т хүрсэн. Нийт хүүгийн бус орлогын 51.1 хувийг гадаад валютын арилжааны орлого, 39.1 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 9.8 хувийг бусад санхүүгийн үйлчилгээ /санхүүгийн түрээс, итгэлцэл, мөнгөн гуйвуулга, санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээ, үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлогууд/-ний орлого тус тус эзэлж байна.

2008, 2009 онууд дахь хүүгийн болон хүүгийн бус орлогын нийт орлогод эзлэх хувь хэмжээнд төдийлэн өөрчлөлт ороогүй байна.

Харин дээрх тайлант онуудын нийт зардлын бүтэц дараах байдалтай байна.

/Хүснэгт 8/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2009.12.31		2008.12.31		Өөрчлөлт	
		Дүн /мян. төг/	Хувь	Дүн /мян. төг/	Хувь	Дүн /мян. төг/	Хувь
1	ХҮҮГИЙН ЗАРДАЛ	2,458,124.1	11.3%	1,440,294.5	9.6%	1,017,829.6	70.7%
2	ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ	16,510,765.2	76.1%	11,461,048.9	76.6%	5,049,716.2	44.1%
3	БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН ЗАРДАЛ	1,799,739.6	8.3%	1,289,014.9	8.6%	510,724.7	39.6%
4	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	288,038.2	1.3%	251,208.8	1.7%	36,829.4	14.7%
5	ЕРДИЙН БУС ЗАРДАЛ	12,403.3	0.1%	4,276.9	0.0%	8,126.4	190.0%
6	ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ	625,577.0	2.9%	513,681.0	3.4%	111,896.0	21.8%
	НИЙТ ЗАРДАЛ	21,694,647.4	100.0%	14,959,525.0	100.0%	6,735,122.4	45.0%

2009 оны жилийн тайлант хугацааны нийт зардал өмнөх оны мөн үеэс 45.0 хувь өссөн ба үүнд хүүгийн зардал, болзошгүй эрсдэлийн зардал, орлогын татварын зардлууд голлох хувийг эзэлж байна. Хэдийгээр, өмнөх онтой харьцуулахад нийт зардал өссөн ч тайлант үеүдийн нийт зардлын бүтцийг харахад, түүнд эзлэх хувь хэмжээний хувьд төдийлэн өөрчлөлт гараагүй байна. Ийнхүү системийн хувьд нийт зардал өсөхөд ББСБ-уудын эзэмшигчийн өмчийн өсөлт, ББСБ-ын тоо өсөн нэмэгдсэнтэй шууд холбоотой.

Нөгөөтэйгүүр, системийн хувьд 2009 оны жилийн тайлант үеийн нийт орлогын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 41.2 хувиар өссөн байхад нийт зардал 45.0 хувийн өсөлттэй байгаа ба активын болзошгүй эрсдэлийн зардлын өсөлт нь ББСБ-уудын зээлийн багцын чанар муудаж, чанаргүй зээлийн хэмжээ байнга өсөн нэмэгдсээр байгааг илтгэж байна.

ББСБ-ууд нь 2009 оны жилийн тайлант хугацаанд нийт 4,986,027.7 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 26.6 хувийн өсөлттэй /2008 оны жилийн тайлант хугацааны цэвэр ашиг 3,937,471.9 мянган төгрөг/ байгаа хэдий ч, энэ үзүүлэлтийг тухайн тайлант үеүдийн нийт орлоготой харьцуулахад 2.2 хувиар буурсан /2008 онд 20.8 хувь, 2009 онд 18.6 хувь/ үзүүлэлттэй байна. Өөрөөр хэлбэл, өмнөх онтой харьцуулахад системийн хувьд нийт ашиг нэмэгдсэн нь үйл ажиллагааны үр ашиг нэмэгдсэн нэмэгдсэнтэй бус, харин ББСБ-уудын активын өсөлт, ББСБ-ын тооны өсөлттэй шууд хамааралтай болохыг харуулж байна.

ББСБ-уудын системийн эзэмшигчдийн өмч, дүрмийн сангийн хэмжээ, татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээг өмнөх онуудтай харьцуулбал дараах байдалтай байна.



Харин сүүлийн 10 жилийн хугацаанд ашгийн нийт орлогод эзлэх хувь хэмжээ дараах байдалтай байна.

/Хүснэгт 9/

Он	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009
Эзлэх хувь	16.7%	8.3%	27.3%	26.8%	19.4%	16.9%	14.3%	19.6%	21.7%	18.7%

ТАВ. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

ББСБ-ын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр Хорооны 2008 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон үзүүлэлтүүд системийн түвшинд дараах байдалтай байна. Үүнд:

- нийт өөрийн хөрөнгө 74,840,502.05 мянган төгрөг, эрсдэлээр жигнэсэн актив 64,153,556.19 мянган төгрөг байгаагаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлт нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хувьд 114.9 хувь, өөрийн хөрөнгийн хувьд 116.8 хувь, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын хувьд 76.4 хувь;

- түргэн борлогдох актив 33,645,290.40 мянган төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 14,207,664.01 мянган төгрөг байгаагаас төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 236.8 хувь;

- гадаад валютаар олгосон зээлийн өрийн үлдэгдэл, кассет байгаа бэлэн валют, банкин дахь валютын харилцах дансан дахь үлдэгдэл нийт 15,623,514.05 мянган төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 7,500,732.37 мянган төгрөг байгаагаас гадаад валютын ханшийн эрсдлийн зохистой харьцаа 10.85 хувь;

- итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийн үлдэгдэл 3,653,513.12 мянган төгрөг, хувьцаат капитал 66,367,214.45 мянган төгрөг байгаагаас итгэлцлийн үйлчилгээний өглөг, хувьцаат капиталын харьцаа 5.5 хувь;

- нийт цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө 1,811,271.35 мянган төгрөг, нийт актив 96,480,115.68 мянган төгрөг байгаагаас үндсэн хөрөнгө, нийт активын харьцаа 1.9 хувь байгаа нь зохистой харьцааны үзүүлэлтүүдийг тус тус хангасан байна.

Харин Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүү, эдийн засгийн сайдын 2004 оны 459/207 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн

сайдын 2009 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 125/50 дугаар хамтарсан тушаалаар баталсан өөрчлөлтийн дагуу активын эрсдэлийн санг 3,432,910.70 мянган төгрөгөөр байгуулбал зохихоос 87,457.90 мянган төгрөгөөр дутуу буюу нийт 3,345,452.80 мянган төгрөгөөр байгуулсан байна.

ЗУРГАА. ДҮГНЭЛТ, ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛБЭЛ ЗОХИХ АРГА ХЭМЖЭЭ

2009 оны жилийн санхүүгийн тайлангийн нэгтгэлээрх нийт активын төвлөрлийн байдлыг харахад 100,000.0 мянга хүртэлх төгрөгийн активтай 54 ББСБ-ын 3,060,990.56 мянган төгрөгийн актив нь нийт активын 3.17 хувийг, 100,000.0 мянгаас 400,000.0 мянга хүртэлх төгрөгийн активтай 47 ББСБ-ын 11,932,256.95 мянган төгрөгийн актив нь нийт активын 12.37 хувийг, 400,000.0 мянгаас 1,000,000.0 мянга хүртэлх төгрөгийн активтай 55 ББСБ-ын 28,407,615.73 мянган төгрөгийн актив нь нийт активын 29.44 хувийг, 1,000,000.0 мянгаас дээш төгрөгийн активтай 21 ББСБ-ын 53,079,252.44 мянган төгрөгийн актив нь нийт активын 55.02 хувийг тус тус эзэлж байна.

Өөрөөр хэлбэл, 21 ББСБ буюу нийт ББСБ-ын 11.9 хувь нь нийт активын талаас илүү хувийг эзэлж байгаа нь бусад ББСБ-ууд тэдэнтэй санхүү, төлбөрийн боломжоороо өрсөлдөх чадвар дутмаг байгааг харуулж байна.

Харин ББСБ-ын нийт актив нь банкны салбарын нийт активын 21.8 хувийг эзэлж байгаа өмнөх оныхоос төдийлэн өөрчлөлт ороогүй хэдий ч нийт эзэмшигчдийн өмчийн дүнг банкны салбарын эзэмшигчдийн өмчийн дүнгтэй харьцуулахад түүний 32.5 хувьтай тэнцэх хэмжээг эзэлж байгаа нь нэг талаас, банкны системийн хувьд нийт эзэмшигчдийн өмчийн хэмжээ буурсан /өмнөх оноос 32.4 хувь буурсан ба үүн дотроо тайлант үеийн алдагдал 114.1 хувиар өссөн/, нөгөөтэйгүүр, ББСБ-ын системийн хувьд өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаагаа явуулдаг онцлогтой уялдан байнга өсөн нэмэгдэж байгаатай холбоотой.

Нийт 177 ББСБ-аас 120 ББСБ тайлант хугацааны эцэст 3,160.8 мянгаас 5,703,863.7 мянган төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй байгаагаас хамгийн их хэмжээний үлдэгдэлтэй нь Кредит Монгол ББСБ /нийт зээлийн өрийн үлдэгдлийн 10.3 хувь/ байна. Харин нийт ББСБ-ын 11.3 хувь болох 20 ББСБ-ын 35,744,708.5 мянган төгрөг /529,603.2 мянган төгрөгөөс дээш буюу нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1-ээс дээш хувь/-ийн зээлийн өрийн үлдэгдэл нь системийн нийт зээлийн өрийн үлдэгдлийн 64.4 хувийг эзэлж байгаа бөгөөд эдгээр ББСБ-ууд нь бүгд 500,000.0 мянган төгрөгөөс дээш хэмжээний дүрмийн сантайгаар Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна.

Нийт эзэмшигчийн өмч банкны салбарын эзэмшигчийн өмчийн 32.5 хувийг эзэлж байгаа бөгөөд системийн нийт эзэмшигчийн өмчийн 48.0 хувийг 23 ББСБ-ын 30,452,198.7 мянган төгрөг /нийт эзэмшигчийн өмчийн 1.02 хувиас 6.3 хувь/ эзэлж байна.

Нийт дүрмийн сангийн хэмжээг банкны салбарын дүрмийн сангийн хэмжээтэй харьцуулахад түүний 25.9 хувьтай тэнцэж байгаа өмнөх оноос 4.5 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Мөн өөрийн хөрөнгийн өсөлтөд Хорооны 2008 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн “Банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 169 дүгээр тогтоолоор үүрэг болгосны дагуу ББСБ-ууд дүрмийн сангаа нэмэгдүүлсэн /2009 оны тайлант хугацаанд нийт 62 ББСБ 14,667,400.4 мянган төгрөгөөр дүрмийн санг нэмэгдүүлсэн ба уг тогтоолын дагуу дүрмийн санг нэмэгдүүлвэл зохих 93 ББСБ-аас 58 ББСБ 11,931.381.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн/, Хорооны 2009 оны “Валютын арилжааг цэгцтэй болгох зорилгоор зарим тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 28 дугаар тогтоолын дагуу шинээр гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх ББСБ шинээр олноор байгуулагдсан нь чухал үүрэг гүйцэтгэсэн.

Тайлант хугацааны санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр ББСБ-ууд нь 1.0 төгрөгийн өөрийн хөрөнгөөс 0.07 төгрөгийн ашиг олж байгаа нь үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэхэд төдийлэн хангалтгүй байгаа мэт харагдаж байгаа ч банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй зарим ББСБ-ын үйл ажиллагаа нь төдийлэн

тогтворжоогүй /2009 оны жилийн тайлангийн нэгтгэлд эхлэлтийн тайлан тэнцэл бүхий 10, өмнөх тайлант хугацаануудын тайлан тэнцэл бүхий 12 ББСБ хамрагдсан/, 33 ББСБ нийт 931,594.0 мянган төгрөг /нийт активын -0.97 хувь/-ийн алдагдалтай ажилласан зэрэг нь тодорхой хэмжээгээр нөлөөлсөн.

Нийт активын 57.5 хувийг зээлийн өрийн үлдэгдэл, 32.2 хувийг мөнгөн хөрөнгө /эдгээр нь нийт активын 89.7 хувь/ эзэлж байгаа нь нэг талаас, системийн хэмжээнд нийт эх үүсвэрийн байршуулалт төдийлэн хангалтгүй байгааг харуулж байгаа бөгөөд нөгөөтэйгүүр, цаашид сул чөлөөтэй мөнгөн хөрөнгөөрөө зээл олголтыг нэмэгдүүлэх, улмаар системийн хувьд нийт ашиг, орлогын хэмжээг өсгөх бодит боломж байгааг харуулж байна. Нөгөөтэйгүүр энэ үзүүлэлт нь ББСБ-уудын үндсэн эрхэлж буй үйл ажиллагаа нь зээлийн үйл ажиллагаа байж, бусад санхүүгийн үйл ажиллагаа, үйлчилгээг төдийлэн эрхлэхгүй байгаатай шууд холбоотой.

2009 онд 123 /2008, 2009 онуудын хөлс төлсөн нийт ББСБ-уудын давхардсан тоогоор 148/ ББСБ нийт 116,959.0 мянган төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн байна.

Хороо “Улс орныхоо санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлын баталгаа байна” зорилтынхоо хүрээнд санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийнхээ дагуу дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна. Үүнд:

1. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Зээлийн батлан даалтын сангийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохтой холбогдуулан холбогдох хуулийн төслийг өргөн барьж хэлэлцүүлэн, батлуулах;
2. Нэмэлт өөрчлөлт оруулсан болон шинээр батлагдсан хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох заавар, журмуудыг шинэчлэн боловсруулах, боловсронгуй болгох;
3. Гадаад, дотоодын хамтын ажиллагааг тогтворжуулах замаар санхүүгийн зах зээлийн тогтвортой хөгжлийн хурдцыг хангах, хамтын ажиллагааны хүрээнд санхүүгийн шинэ бүтээгдэхүүнийг дэмжиж ажиллах;
4. ББСБ-уудаас хүлээн авах санхүүгийн тайлан мэдээ, мэдээллийг цуглуулах мэдээллийн сан, нэгдсэн сүлжээтэй болох арга хэмжээг эхлүүлэх;
5. Хорооны Бичил санхүүгийн орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааг идэвхижүүлэх;
6. ББСБ-уудын дийлэнх хэсэг нь зээл, гадаад валютын үйл ажиллагаа эрхлэж байгаа, энэ утгаараа банк бус санхүүгийн үйл ажиллагааг бүрэн цогцоор нь төдийлэн эрхлэхгүй байгаатай холбогдуулан аль болох хуульд заасан санхүүгийн үйл ажиллагааг эрхлэх боломжийг нээх, тэдгээрийн эрх зүйн зохицуулалт, журам зааврыг шинээр боловсруулан батлуулах, улмаар зохицуулалтын байгууллагуудад сургалт хийх замаар таниулах арга хэмжээ авах;
7. ББСБ-тай холбоотой санхүүгийн нэгдэл, бусад холбогдох этгээдийн үйл ажиллагаанд нэгдсэн хяналт, шалгалт хийх ажлын хүрээнд Монголбанк болон төрийн холбогдох бусад байгууллагуудтай хамтран ажиллах;
8. ББСБ-уудын үйл ажиллагаанд хийх газар дээрх хяналт, шалгалтын чанар, үр нөлөөг сайжруулахад анхаарч ажиллах;
9. Хөдөө орон нутаг дахь ББСБ-уудын үйл ажиллагаанд гүйцэтгэх газар дээрх хяналт, шалгалтын ажлыг эрчимжүүлэх;
10. Мэдээллийн сан, мэдээллийн нэгдсэн тогтолцоог сайжруулах замаар ББСБ-уудад тавьж буй зайны хяналтыг сайжруулах;

11. Хорооны 2009 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн “Банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн сангийн доод хэмжээг нэмэгдүүлэх хугацааг сунгах тухай” 191 дүгээр тогтоолоор ББСБ-ын дүрмийн сангийн доод хэмжээг нэмэгдүүлэх хугацааг 2010 оны 3 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл сунгасантай холбогдуулан тогтоолын хэрэгжилтийг хангуулах;
12. Зохицуулалтын байгууллага, тэдгээрийн үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгчид, ажиллагсадад хууль тогтоомж, заавар журмыг таниулах ажлын хүрээнд бүхий л талын арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллах;
13. Банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо болон бусад холбогдох төрийн бус байгууллагуудтай нягт хамтран ажиллах.

БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР